

Уг тендерийн техникийн даалгаврын 34-р хуудас, 2.1. Туршлага ур чадвар хэсэгт “Геотехникийн цогц хөтөлбөр нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэгч нь уул уурхай, геологи хайгуулын салбарт үйл ажиллагаа явуулдаг, хамгийн багадаа 10 жилийн турш олон улсын хэмжээнд уул уурхайн геотехникийн судалгаа, зөвлөгөө өгч ажилласан туршлагатай, олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ASTM ба ISRM стандартын норм, дүрмийн дагуу дээж бэлтгэл, боловсруулалт, шинжилгээний ажлыг гүйцэтгэж захиалагч талд тайлагнах чадвартай, олон улсад итгэмжлэгдсэн геотехникийн зөвлөх инженерүүд экспертууд болон Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг, олон улсын түвшинд хэрэгждэг бусад уурхайн төслүүдэд, олон улсын стандартын шаардлагад нийцсэн системд 3-10 жилийн хугацаанд ажилласан туршлагатай геотехникийн болон бусад холбогдох чиглэлээр ажилласан мэдлэг, туршлагатай Монгол инженерийн техникийн багийн гишүүдийг багтаасан мэргэжлийн боловсон хүчинээр гүйцэтгэлийн багт бүрдүүлсэн бол давуу тал болно.” гэж заасан нь “Гүйцэтгэгч байгууллага нь хамгийн багадаа 10 жилийн хугацаанд олон улсын хэмжээнд уул уурхайн геотехникийн чиглэлээр судалгаа, зөвлөгөө өгч үйл ажиллагаа явуулсан туршлагатай байна” гэсэн утгыг илэрхийлсэн болно.

Мөн тендерийн техникийн даалгаврын 43-р хуудас, 2.4. Бусад шаардлагууд хэсэгт гүйцэтгэгч байгууллагын хүний нөөцийн ур чадвар, туршлагын талаарх шаардлагуудыг тодорхой заасан.